

ХЭРЭГЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЛААР

Засгийн газрын 2010 оны 11-р тогтоолын дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт иргэдийн ахуй амьдрал, амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлж байгааг тодруулах зорилгоор иргэдийн дунд санал асуулгыг 2009 онд 2-удаагийн давтамжтай 13 суманд зохион явуулж 844 иргэн судалгаанд хамрагдлаа. Энэ нь аймгийн насанд хүрсэн хүн амын 3- хувийг эзлэж байна.

Судалгааны ажлыг зохион явуулахдаа “Иргэний нийгмийн сүлжээ” төрийн бус байгууллагыг бие даан оролцох нөхцөл боломжийг хангаж ажиллалаа.

Судалгаанд нийт 844 хүн оролцсоны 318 нь төсөвт байгууллагаас, 155-нь хувийн хэвшил, бизнес эрхлэгчдээс, 144-нь малчин, 155-нь ажилгүй иргэд, 72-нь төрийн бус байгууллагаас хамрагдсан байна.

Судалгааны дүнг үзүүлэлт бүрээр авч үзэн үнэлгээ өгөхөд доорхи байдалтай байна. Үүнд:

ХЭРЭГЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ТҮҮНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

№	Санал асуулгын асуулт	Иргэдийн хариулсан байдал	Өгсөн үнэлгээ (оноо)
1.	Сум, орон нутгийн төрийн байгууллагууд элдэв чирэгдэл учруулахгүйгээр ил, тод, хөнгөн шуурхайгаар танд үйлчилж чадаж байна уу?	Хариулт	-
	а/Хангалттай	149	3.81
	б/Боломжийн хэмжээнд	450	
	в/Хангалтгүй	187	
2.	Танай суманд амьжиргааны түвшин ямар байа вэ?	Хариулт	3.61
	а/ Сайн	50	
	б/Дунд	502	
	в/ Муу	212	
3.	Танай суманд хамгийн ихээр тулгамдаж буй ямар асуудал байна вэ? /3-ыг тодорхойлж зурна уу/	Хариулт	-
	а/Ажилгүйдэл	632	
	б/Ядуурал	321	
	в/Архидалт	261	
	г/Авигал	164	
	д/Хүнд суртал	234	
	е/Үнийн өсөлт	321	
	ё/Өвөлжилт	40	
	з/Малын хулгай	108	
	к/Бусад	4	
4.	Төрийн байгууллагад өгсөн өргөдөл гомдол санал хүсэлтийн шийдвэрлэлт ямар түвшинд байна гэж та үзэж байна.	Хариулт	3.68
	а/Хангалттай	88	
	б/Боломжийн хэмжээнд	485	
	в/Хангалтгүй	205	
	г/Мэдэхгүй	151	

5.	Танай сумын удирдлагууд хэр түвшинд ажиллаж байна вэ?				Хариулт	3.82
	а/ Сайн				216	
	б/Дунд				401	
	в/Тааруухан				190	
6.	Таны бодлоор танай сумын ажилд оршиж буй гол дутагдал юу вэ?				Хариулт	-
	а/Төрийн захиргааны зөв бодлого				170	
	б/Удирдлагын арга барил				220	
	в/Боловсон хүчний чадвар				430	
	г/ Өөр бусад.....				24	
7.	Суманд нэн тэргүүнд хийгдэх шаардлагатай ямар ажил байна вэ? Та саналаа бичнэ үү. /Нээлттэй асуулт-өөрсдөө нөхөж бичих /				Хариулт	-
	а/Ажлын байр				210	-
	б/Жижиг дунд үйлдвэр				119	
	в/Зам талбайн гэрэлтүүлэг				85	
8.	Байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгнө үү?				Хариулт	-
№	Байгууллагын нэрс	Үнэлгээ	Сайн	Дунд	Тааруу	Оноо
1.	Сумын засаг даргын тамгын газар	Дунд	300	307	111	4.11
2.	Сургууль	Сайн	438	262	69	
3.	Цэцэрлэг	Сайн	455	227	57	
4.	Соёлын төв	Дунд	269	309	121	
5.	Хүн эмнэлэг	Дунд	346	274	104	
6.	Мал эмнэлэг	Дунд	203	287	141	
7.	Цагдаа	Дунд	240	329	145	
	Дундаж оноо	-	-	-	-	3.80

Нийт оноо-3.80
Гүйцэтгэл- 76.0

Судалгааны нийт 8 асуултын 3- нь аймаг, сумын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох асуулт байсан бөгөөд судалгааны дүнгээс харахад ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнд суртал, үнийн өсөлтийн асуудлуудад аймаг орон нутгийн зүгээс анхаарч, бодлого, төлөвлөлтөө чиглүүлж ажиллах шаардлагатай байна. Мөн сум орон нутгийн түвшинд боловсон хүчний чадварыг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг олноор нэмэгдүүлж ажиллах нь тулгамдсан гол асуудал болоод байгааг ч судалгаа харуулж байгаа юм.

Иймээс судалгааны дүнг үндэслэн сумдын Засаг дарга, Тамгын газар, агентлаг албадад холбогдох зөвлөмж чиглэлийг өгч ажиллаж байна.